



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 01 өдөр

Дугаар A/133


Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.7 заалтууд, Засгийн газрын 2020 оны 7 дугаар сарын 29-ний “Боловсролын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоол, засгийн газрын Шадар сайд, Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2020 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн “Хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай” 78, 149, А/164, А/14, А/391 тоот хамтарсан тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн А/21 тоот тушаалаар батлагдсан “Их, дээд сургууль коллежийн хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын 1.1, 1.4, 2.2, 4.1 заалтууд, Захирлын зөвлөлийн 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улирлын сургалтыг “Сургалтын нэгдсэн хуанли”-ийн дагуу цахим хэлбэрээр, 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс лекцийн хичээлийг үргэлжлүүлэн 100% цахимаар, семинар, практик, лабораторийн хичээлийг сургалтын төлөвлөгөөний дагуу танхимаар зохион байгуулсугай.
- Өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх удирдамжийг хавсралтаар баталсугай.
- Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, батлагдсан удирдамжийг мөрдөн ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Х.Энхжаргал), Сургалтын бодлого, зохицуулалтын газрын дарга (Д.Гэрэлт-Од), Мэдээллийн технологийн төвийн захирал (Р.Төрбат), Нээлттэй боловсролын төвийн захирал (Д.Ганбат), бүрэлдэхүүн сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.


ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ

367040791

ШУТИС-ийн захирлын 2020 оны 09 дүгээр сарын
02-ны өдрийн 113 тоот тушаалын хавсралт



Өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх удирдамж

НЭГ. Элсэлт, шилжилтийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт

1.1 Элсэлт

- Ерөнхий боловсролын ахлах сургууль, Коосэн технологийн коллеж, бакалаврын хөтөлбөрт элсэгчдийн бүртгэл, элсэлтийн шалгалтыг цахимаар зохион байгуулна.
- Магистр, докторын хөтөлбөрт элсэгчдийн гадаад хэлний шалгалт цахимаар, мэргэжлийн ярилцлага хорио цээрийн журмыг баримтлан бүрэлдэхүүн сургууль бүр дээр явагдана.

1.2 Шилжилт

- Гадаад, дотоодын их дээд сургуулиас шилжин ирж суралцах болон хөтөлбөр хооронд шилжин суралцах хөдөлгөөнийг журмын дагуу зохион байгуулна.

ХОЁР. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт

2.1 Сургалтын үйл ажиллагаа

- “Цахим сургалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг баримтлан ажиллана.
- Цахим хичээлийн материалыг (лекц, семинар, лаборатори, практик) хичээлийг хуваарийн дагуу 7 хоног бүрээр, намрын улирал дуустал платформд байршуулна.
- Намрын улирлын сургалтыг “Сургалтын нэгдсэн хуанли”-ийн дагуу 100% цахим хэлбэрээр, 10 дугаар сарын 5-ны өдрөөс лекцийн хичээлийг үргэлжлүүлэн 100% цахим хэлбэрээр, семинарын хичээлийг 40 суралцагчтай, ширээ хоорондын зайг 1-1,5 метр байхаар танхимын сургалтаар, сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.
- Лабораторийн хичээлийг 10 дугаар сарын 5-наас лабораторид 20 суралцагчтай, ширээ хоорондын зайг 1-1,5 метр байхаар зохион байгуулах бөгөөд дээрх хугацаа хүртэл тасалдсан хичээлийг агуулгаар нөхөж орно.
- Практикийн хичээлийг 10 дугаар сарын 5-наас танхимд 30 суралцагчтай, ширээ хоорондын зайг 1-1,5 метр байхаар зохион байгуулах бөгөөд дээрх хугацаа хүртэл тасалдсан хичээлийг агуулгаар нөхөж орно.
- Бие даалтын даалгавар гүйцэтгэх хугацааг 14 хоногоос багагүй байхаар тогтооно.



2.2 Шалгалт

- Явцын шалгалтыг цахимаар эсвэл танхимд 40 суралцагчтай зохион байгуулж болно.

2.3 Биеийн тамирын хичээл

- Биеийн тамирын хичээл нь “Сургалтын нэгдсэн хуанли”-ийн дагуу 10 дугаар сарын 5-ны өдөр хүртэл цахимаар орох бөгөөд 10 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн цахим болон спорт зааланд (40 суралцагчтай) хосолсон байдлаар хичээллэнэ.

2.4 Дадлага

- Салбар, тэнхимийн саналаар дадлагыг холбогдох газруудад 10 дугаар сарын 5-ны өдөр хүртэл ганцаарчлан, 10 дугаар сарын 5-ний өдрөөс 40 суралцагчтай байхаар зохион байгуулна.
- Өмнөх улиралд цуцлагдсан дадлагыг 10 дугаар сарын 5-ны өдрөөс хойш 40 суралцагчтай байхаар зохион байгуулах ба 9 дүгээр сард зайлшгүй хийх шаардлагатай, намрын улирлын сургалтын үйл ажиллагаанд саад болохгүй хийх боломжтой хээрийн дадлагыг салбар, тэнхимээс гаргасан санал, удирдамжийн дагуу тухайн орон нутагт нь ганцаарчлан хийлгэж болно.

ГУРАВ. Оюутны дотуур байртай холбоотой зохицуулалт

- 3.1 Оюутны дотуур байранд суух бүртгэлийг 8 дугаар сарын 20-ны өдрөөс 9 дүгээр сарын 05-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулна.
- 3.2 Дотуур байранд орохоор бүртгэл нь баталгаажсан оюутан, суралцагчийг 10 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд хүлээн авах бэлтгэл ажлыг хангана.

----- оОо -----